



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 4/91

Батширээт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. "People in Need" олон улсын байгууллагаас "Хээрийн түймрийн эрт арга хэмжээ" төслийн хүрээнд Батширээт сумын Засаг даргын Тамгын газарт интернэтийн Старлинк төхөөрөмж, түймэр унтраах үлээгч аппарат, иж бүрэн хувцас хэрэглэл хүлээлгэн өгч, Онцгой байдлын Ерөнхий газрын 2023 оны "Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн дүрэм"-ийн дагуу Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга, хурандаа Ж.Эрдэнэбатаар ахлуулсан ажлын хэсэг иргэдэд сургалт, дадлага зохион байгуулсан зардалд 303,000 (гурван зуун гурван мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Гамшгийн эрсдэлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501179